# МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ

# 2011

## ХУВИЛБАР А

1. Монгол нутагт 800 мянган жилийн тэртээ эртний хүн амьдарч байсныг юугаар нотолдог вэ?
   A. Эртний хүний яс B. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл C. Хадны сүг зураг
   D. Булш бунхан E. A болон D зөв
2. Эртний хүмүүсийн амьдралд нум сум хэрэглэх болсон үе аль үед хамаарах вэ?
   A. Хуучин чулуун зэвсэг B. Шинэ чулуун зэвсэг C. Хүрэл зэвсэг
   D. Төмөр зэвсэг E. Дунд чулуун зэвсэг
3. Хэдий үед Монгол орон эх газрын, эрс тэс, хуурай сэрүүн уур амьсгалтай болсон бэ?
   A. 100 000 жилийн тэртээгээс B. 40 000 жилийн тэртээгээс
   C. 15 000 жилийн тэртээгээс D. 8 000 жилийн тэртээгээс
   E. 3 000 жилийн тэртээгээс
4. Хэдий үед чулуун иртэй ясан хутга, ясан зэв, шөвөг, ясан зүүлт, бугуйвч зэргийг өргөн хэрэглэх болсон бэ?
   A. Дунд палеолитын үед B. Дээд палеолитын үед C. Мезолитын үед
   D. Неолитын үед E. Энеолитын үед
5. Монгол нутагт өргөн тархсан хиргисүүр нь аль үед хамаарагдах дурсгал вэ?
   A. Хуучин чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг C. Шинэ чулуун зэвсэг
   D. Хүрэл зэвсгийн үе E. Хүннү
6. Хүрэл, төмрийн түрүү үеийн томоохон дурсгал, бие даасан соёл болох “Чандманий дурсгал” хаана байдаг вэ?
   A. Ховд аймгийн Манхан сум B. Ховд аймгийн Чандмань сум
   C. Увс аймгийн Улаангом сум D. Увс аймгийн Сагил сум
   E. Баян-Өлгий аймгийн Улаан хус сум
7. Аль нь Нирун (Жужан) нарын уугуул нутаг вэ?
   A. Цагаан хэрмээс Байгаль нуур, Солонгосын хойгоос Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв
   B. Хянганы нуруугаар төвлөрч, Шар мөрнөөс Эргүнэ мөрөн, Дорнодын талаас Ляохэ голын эх хүрч байв
   C. Ордосоос Байгаль нуур өнгөрч, Алтайн нуруунаас Дорнодын тал хүрч байв.
   D. Хангайн нуруугаар төвлөрөн Их элсэн говиос Байгаль нуур, Хянганы нуруунаас Алтайн нуруу хүрч байв
   E. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх уудам нутагт оршин тогтнож байв
8. Аль нь Хүннү улсын цэрэг вэ?
   A. Хатуу нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
   B. Даргай нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
   C. Нум сумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
   D. Төмөр жадаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
   E. Хүнд морин цэрэг
9. Аль улс нь их, бага хоёр бичигтэй байсан бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Хятан
10. Түрэгүүд нас барагсдаа хэрхэн оршуулдаг байсан бэ?
    A. Шарилыг нь чандарлаад, тахилын сүм барьж, хөрөг дүрсийг нь залж, дайнд оролцож явсан тухай нь тэмдэглэдэг
    B. Шарилыг нь занданшуулж, тахилын сүм барьж, хөргийг нь зурж, гавъяа зүтгэлийг нь тэмдэглэдэг
    C. Шарилыг нь хатааж, тахилын сүм барьж, хөргийг нь залж, дайны олзноос дагалдуулдаг
    D. Шарилыг нь чулуун хашлагатай бунханд, ихэвчлэн ил тавьж, мал дагалдуулан
    E. Шарилыг нь шороон хашлагатай бунханд, эсгийнд ороож, морь дагалдуулан
11. Од гаригийн хөдөлгөөн, хүн амьтны амьдралын мөчлөгт тулгуурлаж 12 жилийн цаг тоолол бий болгож хожмын жарны тооллын үндсийг тавьсан улс аль нь вэ?
    A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
12. XI-XII зууны үед язгуурын Монгол аймгууд Нирун ба Дарлигин гэсэн хоёр бүлэгт хуваагддаг байжээ. Дарлигин аймгууд гэж ямар овог аймгийнхныг нэрлэдэг вэ?
    A. Добу мэргэний бэлэвсэн хатан Алунгоогийн гурван хөвгүүдийн удмаас үүсэлтэй овог аймаг
    B. “Эргүнэ гүн” очсон Нукуз, Хиян хоёр овгоос үржин олон болсон Эргүнэ гүний Монголчууд
    C. Хамаг Монголоос бусад ханлиг аймгууд
    D. Хамаг Монголын ханлигийн бүрэлдэхүүнд багтах бүх овог, аймгууд
    E. Хабул хааны удмынхан

13. Хамаг Монголын ханлигийн анхны хан хэн бэ?
    A. Хабул B. Амбагай C. Хотула D. Тэмүжин E. Есүхэй
14. “Монголын нууц товчоо”-нд Өэлүн эх, “... Ханиа барагсад, Харвисаа хазах хасар нохой мэт, Сүүдрээс өөр нөхөр үгүйд, Сүүлнээс өөр ташуур үгүйд” гэхчилэн хэнийг, юуны учир зэмлэдэг вэ?
    A. Тэмүжин, Хасар хоёрыг Бэгтэрийг хороолоо хэмээн
    B. Тэмүжинг Жамухаас хагацан нүүв гэж
    C. Тэмүжинг Хасарыг буруутган байцаасан гэж
    D. Тэмүжинг Тоорил ханаас нүүр буруулах болов гэж
    E. Өэлүн эх тийм үг хэлээгүй
15. Дараах зүтгэлтнүүдийн аль нь Чингис хааны “Дөрвөн хүлэг баатар”-т багтах вэ?
    A. Хар хирүгэ, Чуу мэргэн, Шихихутаг, Сорхон шар
    B. Боорчу, Мухулай, Борохул, Чулуун
    C. Чулуун, Чимбай, Зургаадай, Зэв
    D. Зэв, Чулуун, Чимбай, Мухулай
    E. Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбээдэй
16. Тэмүжинг хэзээ, хаана Хамаг Монгол улсын хаанаар өргөмжилсөн бэ?
    A. 1162 онд Онон мөрний эхэнд B. 1189 онд Хэрлэнийн Хөдөө аралд
    C. 1206 онд Орхоны савд D. 1189 онд Хар зүрхэний Хөх нуурт
    E. 1189 онд Балжун нуурт
17. Их Монгол улсын төрийн гол хууль нь ямар нэртэй байсан бэ?
    A. Их цааз B. Их засаг C. Үндсэн хууль
    D. Цааз хууль E. Бага цааз
18. Хэзээ, хаана Их Монгол улс байгуулагдсаныг даяар олонд тунхаглан зарласан бэ?
    A. 1189 онд, Хар зүрхэний Хөх нуурт B. 1206 онд Хэрлэнийн Хөдөө аралд
    C. 1206 онд Онон мөрний эхэнд D. 1206 онд Ононы Дэлүүн болдогт
    E. 1206 онд Хархорумд
19. Хэн Төвдийн лам Пагваг улсын багшаар өргөмжилсөн бэ?
    A. Мөнх хаан B. Хубилай хаан C. Алтан хаан
    D. Түмэн засагт хаан E. Автай сайн хаан
20. 1617 онд Авга хар уул гэдэг газар нийслэл Очир Цагаан хот байгуулсан хаан хэн бэ?
    A. Цогт хунтайж B. Түмдийн Алтан хаан C. Түмэн засагт хаан
    D. Цахарын Лигдэн хан E. Автай сайн хаан
21. Чингис хаан байлдан дагууллаар эзлэн авсан газар нутгаа амьд ахуйдаа 4 хүүдээ хэрхэн яаж хувааж өгсөн бэ? Тохируулна уу.

| | |
|---|---|
| 1. Зүчи | a. Уугуул монгол нутаг |
| 2. Цагаадай | в. Эрчис мөрнөөс баруун тийш монгол морьдын туурай хүрсэн газар нутаг |
| 3. Өгөдэй | c. Тарвагатайн нуруу орчмын нутаг |
| 4. Тулуй | d. Зүүн зүг Турфан, баруун зүг Амударьяа мөрөн, умар зүг Тарвагатай, өмнө зүг Энэтхэгийн уулсыг давсан газар нутаг |

    A. 1a, 2e, 3d, 4в B. 1в, 2d, 3c, 4a C. 1c, 2a, 3a, 4e
    D. 1d, 2c, 3в, 4e E. 1e, 2a, 3e, 4c
22. Хэн, хэзээ шашны тэргүүн Анхдугаар богд Жавзандамба хутагтаар өргөмжлөгдсөн бэ?
    A. 1275 онд Төвдийн Пагва Лам B. 1639 онд Занабазар
    C. 1577 онд Төвдийн Содномжамц D. 1586 онд Автай сайн хаан
    E. 1418 онд Богд Зонхав
23. Хэн сумыг захирч, аливаа хэргийг эрхлэн хариуцдаг байсан бэ?
    A. Засаг ноён B. Захирагч C. Мэйрэн
    D. Залан E. Занги
24. Өгөдэй хааны үед бий болж, улмаар улам бүр хөгжсөөр 1949 он хүртэл байсан алба юу вэ?
    A. Цэрэг B. Өртөө C. Харуул
    D. Сүрэг адуулах E. Ангийн үсний
25. Хэзээ, хаана болсон чуулганаар Манжийн Энх-Амгалан хаан Халх Монголыг Манж чин улсын харъяанд орсныг албан ёсоор тунхаглан зарлав.
    A. 1686 онд Заг Байдрагийн Хүрэн бэлчирийн чуулганаар
    B. 1640 онд Тарвагатайн Улаан бураагийн чуулганаар
    C. 1727 онд Буурын чуулганаар
    D. 1688 онд Ар элстэйн чуулганаар
    E. 1691 онд Долнуурын чуулганаар

26. 1686 онд Заг Байдрагийн Хүрэн бэлчирийн чуулганаар ямар асуудал хэлэлцсэн бэ?
    A. Монгол- Ойрадын Их цаазыг
    B. Халхын баруун, зүүн гарыг эвлэрүүлэх асуудлыг
    C. Халхын хувь заяаны асуудлыг
    D. Хил тогтоох асуудал
    E. Манж Чин улсад дагаар орох асуудал
27. Жамух, Тэмүжин нар анх чухам юугаа солилцож анд болсон бэ?
    A. Шагай
    B. Нум сум
    C. Морь
    D. Бүс
    E. Малгай
28. Аль үеийг түүхэн сурвалжид "Гар газар, хөл хөсөр" байсан үе хэмээн тэмдэглэдэг вэ?
    A. Алтан хааны үеийг
    B. Бага хаадын үеийг
    C. Улс төрийн бутралын үеийг
    D. Батмөнх даян хааны үеийг
    E. Түмэн Засагт хааны үеийг
29. Манжийн эрхшээлийн үеийн Богд Жавзандамба болон хутагтуудын шавь нарын засаг захиргааны зохион байгуулалт ямар байсан бэ? (3 оноо)
    A. Аймаг, отог, хошуу
    B. Хошуу, отог, сум
    C. Отог, сум, баг
    D. Сум, баг, арван
    E. Отог, баг, арван
30. Үйл явдлын цаг хугацааг тогтоно уу.

| | |
|---|---|
| 1. 1866 онд | a. Ховдын хязгаарт бослого гарав |
| 2. 1903 онд | в. Өвөр Монголын Ордос хошуунд дугуйлан байгуулагдав |
| 3. 1880 онд | c. Засагт хан аймгийн Цэцэг нуурт Аюуш дугуйлан байгуулан тэмцэв |
| 4. 1890-ээд онд | d. Сайн ноён хан аймгийн Онолтын удирдсан бослого |
| 5. 1900 онд | e. Улиастайд Энхтайваны удирдсан бослого гарчээ |

    A. 1c, 2a, 3в, 4d, 5e
    B. 1в, 2a, 3c, 4d, 5e
    C. 1a, 2d, 3в, 4e, 5c
    D. 1в, 2c, 3d, 4a, 5e
    E. 1a, 2c, 3e, 4d, 5в
31. Юань улсын гүйцэтгэн захирамжлах дээд байгууллага аль нь вэ?
    A. Ерөнхий яам
    B. Түшмэлийн яам
    C. Ёслолын яам
    D. Дотоод бичгийн яам
    E. Нууц бичгийн яам
32. Давааны арын Монголчууд хэмээх томъёолол аль хааны үед холбогдох вэ?
    A. Чингис хаан
    B. Өгөдэй хаан
    C. Гүюг хаан
    D. Мөнх хаан
    E. Хубилай хаан
33. Манж Чин улсын эрхшээлд орсон дарааллыг зөв болгоно уу.
    A. Өвөр Монгол, Халх Монгол, Ойрад Монгол
    B. Өвөр Монгол, Ойрад Монгол, Халх Монгол
    C. Ойрад Монгол, Өвөр Монгол, Халх Монгол
    D. Халх Монгол, Өвөр Монгол, Ойрад Монгол
34. Өлзийт хунгоо бэхич хэмээх бэрийнхээ өнгөнд шунаж, улмаар Ойрадын Хутхай таюуг хилсээр хороон, дөрвөн Ойрад харь дайсан болоход нөлөө үзүүлсэн хаан аль нь вэ?
    A. Тогоонтөмөр хаан
    B. Аюушридар хаан
    C. Төгстөмөр хаан
    D. Элбэг хаан
    E. Гүнтөмөр хаан
35. Зүүнгар улсыг хэн, хэдэн онд үндэслэн байгуулсан бэ?
    A. 1452 онд Эсэн тайш хаан
    B. 1620 онд Очирт сэцэн хан
    C. 1634 онд Эрдэнэбаатар хунтайж
    D. 1676 онд Галдан бошгот хаан
    E. 1689 онд Цэвээнравдан хаан
36. 1911 оны зун Орос улсаас тусламж эрсэн төлөөлөгчид ямар бичиг авч явсан бэ?
    A. VIII богд Жавзанзамба хутагтын бичиг
    B. Халхын 4 аймгийн хангуудын бичиг
    C. Эрдэнэ шанзудбын яаманд болсон зөвлөлгөөнөөс гаргасан бичиг
    D. Богд уулын арын ой дотор болсон зөвлөгөөнөөс гаргасан бичиг
    E. VIII Богд Жавзандамба хутагт болон Халхын 4 аймгийн хангууд нэр хамтатган өргөсөн бичиг
37. 1915 оны эхээр учир битүүлгээр нас барсан төрийн зүтгэлтэн хэн бэ?
    A. Чин ван Ханддорж
    B. Да лам Цэрэнчимэд
    C. Сайн ноён хан Намнансүрэн
    D. Түшээ гүн Чагдаржав
    E. Шанзудба Бадамдорж
38. Богд хаант Монгол улсын засгийн газрын Гадаад яамны тэргүүн сайдад хэнийг тохоон томилсон бэ?
    A. Чин ван Ханддорж
    B. Да лам Цэрэнчимэд
    C. Түшээ гүн Чагдаржав
    D. Далай ван Гомбосүрэн
    E. Эрдэнэ ван Намсрай

39. 1913 оны сүүл, 1914 оны эхээр Монгол улсын ерөнхий сайд Т.Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдөд Орос улс ямар болзол тулгасан бэ?
   A. Монгол цэргийг Өвөр Монголоос гэдрэг татах
   B. Хиагтад болох гурван улсын хэлэлцээрт төлөөлөгчөө оролцуулах
   C. Нармай Монголын хөдөлгөөнөөс татгалзах
   D. А, В зөв
   E. Бүгд зөв
40. 1911 оны хувьсгалын үр дүн, түүхэн ач холбогдол юу вэ?
   1. Манж Чин улс мөхөх үндсийг тавьсан
   2. Ар монголчууд тусгаар тогтнолоо олж, монгол улс сэргэн мандах эхлэл тавигдав
   3. Манж чин улсын шинэ засгийн бодлогыг таслан зогсоосон
   4. Монголчуудыг хятадчилан уусгах гэсэн хорт бодлогыг таслан зогсоож, үндэс угсаагаа авран хамгаалав
   5. Хятадын санаархлыг тасалж чадсан
   A. 1, 4 B. 2, 5 C. 1, 5 D. 2, 4 E. 4, 5
41. Монголчуудын Манжийн ноёрхлын эсрэг тэмцлийн хамгийн өргөн дэлгэрсэн түгээмэл хэлбэр нь ямар тэмцэл байсан бэ?
   A. Дугуйлан цуглаан B. Бослого тэмцэл C. Зарга
   D. Алба хаях E. Үймээн дэгдээх
42. Монголын төрийн тусгаар тогтнолын төлөөх үйл хэргийг шууд удирдан, зохицуулах үүргийг хэн хүлээсэн бэ?
   A. VIII богд Жавзандамба хутагт B. Чин ван Ханддорж
   C. Да Лам Цэрэнчиэд D. Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар
   E. VIII богд, Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан
43. Өвөр монголыг чөлөөлж явсан монгол цэргийг гэдрэг татсанаар монгол туургатнаа нэгтгэх тэмцэл тасалдаж, цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон билээ. Тийнхүү Өвөр Монголыг чөлөөлж явсан монгол цэргийг буцааж татсан шалтгаан юу вэ?
   A. Монгол улс эдийн засаг, хүн хүчний хувьд хүчин дутаж аргагүйдсэн
   B. Олон мянган цэргээ хядуулахаас болгоомжилсон.
   C. Хятад цэрэг хүн хүчний болоод зэвсгийн хувьд илт давуу байсан
   D. Хаант Оросын шаардлагад автсан
   E. Өвөр Монголын талаас дэмжлэг дутсан
44. Богд хаант Монгол Улсын Засгийн газрын Цэргийн яамны тэргүүн сайдад хэнийг тохоон томилсон бэ?
   A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. Түшээ гүн Чагдаржав
   D. Далай ван Гомбосүрэн E. Эрдэнэ ван Намсрай
45. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн шийдсэн бэ?
   A. Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
   B. Нийт Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
   C. Нийт Монголд Хятадын харьяаны автономит эрх олгосон
   D. Зөвхөн Ар Монголд Хятадын харьяаны автономит эрх олгосон
   E. Нийт Монголыг Хятадын харьяаны жирийн муж болгосон
46. Хаант Орос Улсын туслалцаатайгаар байгуулагдсан цэргийн сургуульд монгол цэргийн анхны бага дарга нарыг бэлтгэж байсан. Энэ сургууль хаана байгуулагдсан бэ?
   A. Улиастай B. Хиагт C. Ховд
   D. Хужирбулан E. Алтанбулаг
47. Хүрээний бүлгэмийн үндэслэгчид хэн бэ?
   A. Д.Сүхбаатар, М.Дугаржав, Жамъян B. С.Данзан, Д.Сүхбаатар, Ө.Дэндэв
   C. М.Дугаржав, С.Данзан, Ө.Дэндэв D. С.Данзан, Ө.Дэндэв, Д.Догсом
   E. С.Данзан, Д.Сүхбаатар, Галсан
48. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920 оны 06-р сарын 25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ?
   A. Намын хүмүүсийн дагаж явах тангарагийн бичгийг баталсан
   B. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон
   C. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн
   D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн
   E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн
49. Хэн хэн ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчөөр томилогдсон ардын намын анхны долоод багтсан бэ?
   A. С.Данзан, Х.Чойбалсан, Ө.Дэндэв B. Д.Бодоо, Д.Чагдаржав, М.Дугаржав
   C. С.Жамъян, А.Жигмиддорж, С.Данзан D. Х.Чойбалсан, Магсаржав, Ширнэндамдин
   E. Д.Сүхбаатар, Д.Догсом, Д.Лосол

50. Халх голын байлдаанд онцгой гавъяа байгуулж, БНМАУ-ын баатар цолоор хэн хэн шагнуулсан бэ?
    A. Аюуш, Дандар, П.Чогдон
    B. Данзанваанчиг, Дандар, Экей
    C. Дампил, Дандар, Гэлэгбаатар
    D. Дандар, Экей, Олзвой
    E. Жанчив, Гэлэгбаатар, Дандар
51. Монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсууд дор бүрнээ цааз гарган хатуу чанд мөрдүүлж байсан тухай түүхэн сурвалж бичгүүдэд олонтаа дурьдагддаг. Дараах өгөгдлийг зөв харгалзуул. (A, B, C, D, E тус бүрд харгалзах утгыг 1, 2, 3, 4, 5-аас сонгоно уу).

| | |
|---|---|
| A. Нирун | 1. Хүний өмнөөс иртэй, үзүүртэй зүйл гаргавал шийтгэж байв |
| B. Уйгар | 2. Морь худалдахыг хориглосон хууль гаргаж, зөрчигсдийг цаазалж байв |
| C. Хүннү | 3. Засаг захиргаа-цэргийн шинжтэй хууль гаргасан ба уг хуулинд цэргүүд морь, зэвсэг нум сумаа, зөв хэрэглэх зэрэг цэргийн сахилга батын тухай заалт орсон байна |
| D. Сүмбэ | 4. Чөдөртэй морь хулгайлагсад, бусдын гэргийтэй нөхцөгсдийг цаазаар авдаг байв |
| E. Түрэг | 5. Хулгай хийсэн хүний толгойг авч, эцгийнх нь хүзүүнд хэсэг хугацаагаар зүүдэг байжээ |

    A. A5, B3, C1, D2, E4
    B. A1, B3, C5, D2, E4
    C. A3, B5, C1, D2, E4
    D. A5, B2, C1, D3, E4
    E. A4, B3, C1, D2, E5
52. XIII зууны II хагаст буюу ……………онд ……….. үсгийг ……………………….. зохиожээ. (Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу)
    A. Али гали – 1587 – Аюуш гүүш
    B. Дөрвөлжин – 1269 – Чойжи-Одсэр
    C. Тод – 1648 – Зая бандид Намхайжамц
    D. Соёмбо – 1686 – Өндөр гэгээн Занабазар
    E. Дөрвөлжин – 1269 – Пагва лам
53. Эцэг, хүү, ач, гучийн холбоотон аль нь вэ? Зөв хариуг сонгоно уу.
    A. Есүхэй, Чингис, Цагаадай, Бат
    B. Есүхэй, Тэмүжин, Зүчи, Бат
    C. Есүхэй, Өгэдэй, Гүюг, Бэрх
    D. Есүхэй, Тэмүжин, Аригбөх, Гүюг
    E. Есүхэй, Тэмүжин, Тулуй, Гүюг
54. 1227 онд Чингис хаан таалал төгсчээ. Чингис хаан таалал төгссөн оныг зууны тоололд шилжүүлнэ үү.
    A. XII зуун
    B. XIII зуун
    C. XII зууны I хагас
    D. XIII зууны I хагас
    E. XIV зууны I хагас

## ХУВИЛБАР B

1. 800 мянган жилийн тэртээ монгол нутагт хүн амьдарч байсныг нотлох олдворууд хаанаас олдсон бэ?
    A. Хэнтий аймгийн Биндэр сумын Өглөгчийн гол
    B. Төв аймгийн Баянцагаан сумын Баян-Айраг
    C. Увс аймгийн Улаангом сумын Чандманий соёл
    D. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
    E. Сүхбаатар аймгийн Онгон сумын Бүрдийн эрэг
2. Эртний хүмүүсийн хамгийн анх эрхэлж байсан аж ахуй аль нь вэ?
    A. Мал аж ахуй
    B. Газар тариалан
    C. Нүүдлийн мал аж ахуй
    D. Ан гөрөө
    E. Газар тариалан мал аж ахуй
3. Хэдий үед Монгол орны голлох уул нуруud, өндөрлөг хэсэг мөсөнд хучигдсан бэ?
    A. 800 000 – 100 000 жилийн үед
    B. 100 000 – 40 000 жилийн үед
    C. 40 000 – 15 000 жилийн үед
    D. 15 000 – 8000 жилийн үед
    E. 800 000 – 15 000 жилийн үед
4. Хаанаас гурван чулуу тулгалан босгож дээр нь бөмбөгөр ёроолтой шавар сав суулгасан, тулга, тогооны үүслийг мэдэж болохуйц дурсгал олдсон бэ?
    A. Тамсагбулагийн суурингаас
    B. Норовлингийн бууцнаас
    C. Баянзагийн бууцнаас
    D. Зуухын суурингаас
    E. Рашаан хадны суурингаас
5. Монгол нутагт өргөн дэлгэрсэн буган хөшөөнд ихэвчлэн юу дүрсэлсэн байдаг вэ?
    A. Морь унасан болон морин тэрэгтэй хүмүүс
    B. Ан хийж байгаа хүмүүс
    C. Буга агнаж байгаа хүмүүс, нар сар, зэр зэвсэг
    D. Нар сар, байгаль дэлхий, хүн, зэр зэвсэг
    E. Нар сар, буга, зэр зэвсэг

6. “Үргэлжийн салхитай байдаг уулын онь хөтөл дээр галлах амыг нь салхи өөд харуулсан зуух барьж, түүнд илч ихтэй түлш хийн, тэр түлш дээрээ төмрийн хүдэр овоолоод гал оруулж төмөр хайлан авна”. Энэ төмөрлөг боловсруулалтын ямар арга вэ?
   A. Хяс B. Бух дарах C. Хөөрөгдөх D. Тулмаар хөөрөгдөх E. Ийм арга байхгүй
7. Аль нь чулуу, төмөр боловсруулах талаараа эртний улсуудын дунд тэргүүлж байсан бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
8. Аль нь барилга хот байгуулалтаараа эртний улсууд дотроосоо илүү байв?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Хятан
9. Аль улс нь Төв Азийн нүүдэлчид ба Хятадын харилцаанд үндсэн эргэлт гаргасан бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
10. Аль нь Нирун улсын цэрэг вэ?
   A. Хүнд морин цэрэг B. Хатуу нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
   C. Нум сумаар зэвсэглэсэн морин цэрэг D. Зэвсэггүй морин цэрэг
   E. Даргай нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
11. Эртний улсуудын аль улсынх нь нийгэмд нийгмийн ялгарал бүр тодорхой болсон бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
12. Эртний монголчууд бөөгийн шашин шүтэж ирсэн уламжлалтай билээ. Удган гэж ямар хүнийг нэрлэж байсан бэ?
   A. Эрэгтэй бөө B. Эмэгтэй бөө C. Зан үйл хийдэг хүн
   D. Өндөр настай хүн E. А ба В
13. Хамаг Монголын ханлиг хаагуур нутаглаж байсан бэ?
   A. Онон, Орхон, Сэлэнгийн сав B. Хөлөн, Буйр нуураар
   C. Хэрлэн, Онон, Туулын сав D. Халх голын сав нутаг
   E. Орхоны адаг, Сэлэнгийн дунд бие
14. “Монголын нууц товчоо”-г олон арван жил судлан шинжээд “... Халцгай цөлд ганц өндөр нарс ургадаггүй, өндөр нарс их ойн дунд өндөр, нам олон нарсны зэргэлдээ ургадаг биш үү. Тэрчлэн өндөр сайхан нарс мэт сүндэрлэсэн Нууц товчоо гэдэг зохиол бол тэр цагт байсан яруу сайхан олон зохиолын нэг мөн гэж бодож болно” хэмээн хэлсэн эрдэмтэн аль нь вэ?
   A. Ц.Дамдинсүрэн B. Д.Цэрэнсодном C. Б.Сумъяабаатар
   D. Ш.Бира E. Ш.Чоймаа
15. Дарлигин Монголчууд хэзээ, хэний удирдлагаар эх нутагтаа эргэн ирж, хаана нутагласан бэ?
   A. VIII зууны эхээр, Гоо маралаар, Онон голд
   B. VIII зууны дундуур, Есүхэй баатараар Хэрлэн голд
   C. VIII зууны сүүлийн хагаст, Бөртэ-чоны удирдлагаар, Бурхан халдунд
   D. IX зууны эхээр, Алан-гуагаар, Буур хээрт
   E. IX зууны дундуур, Добу мэргэнээр, туул голд
16. Чингис хаан улсаа хэдэн мянгатад хуваасан бэ?
   A. 90 мянгатад B. 91 мянгатад C. 95 мянгатад
   D. 100 мянгатад E. 108 мянгатад
17. Их Монгол улсын эхний дөрвөн их хааны хаан суусан он цагийн дарааллыг ол.
   A. Чингис, Өгөдэй, Мөнх, Хубилай B. Чингис, Өгөдэй, Хубилай, Мөнх
   C. Чингис, Өгөдэй, Гүюг, Хубилай D. Чингис, Гүюг, Өгөдэй, Мөнх
   E. Чингис, Өгөдэй, Гүюг, Мөнх
18. Чингис хааны үеийн төрийн зүтгэлтнүүдийн нэр цолыг зөв харгалзуул. (4 оноо)
   1. Го ван a. Шихихутуг
   2. Их зайран b. Үсүн өвгөн
   3. Их заргач c. Хөхчү
   4. Их төлөгч d. Мухулай
   A. 1d 2a 3b 4c B. 1d 2c 3a 4b C. 1a 2c 3b 4d
   D. 1b 2d 3a 4c E. 1d 2c 3b 4a
19. Монголын түүхэн дэх дөрвөн их хааныг өсгөн хүмүүжүүлсэн их хатан аль нь вэ?
   A. Есүхэй баатрын хатан Өүлэн эх B. Өгөдэй хааны хатан Турхана
   C. Гүег хааны хатан Огула хаймиш D. Тулуйн хатан Сорхагтан бэхич
   E. Хубилай хааны хатан Чимбай
20. Бурхны шашны хөлгөн судар 108 боть Ганжуурыг 33 эрдэмтнээр орчуулуулж, алтан үсгээр бичүүлэн залж төрийн гурван эрдэнийн нэг болгосан хаан хэн бэ?
   A. Цогт хунтайж B. Түмдийн Алтан хаан C. Түмэн засагт хаан
   D. Цахарын Лигдэн хаан E. Автай сайн хаан

21. Зургаан түмэн монголын баруун түмэнд багтаж байсан түмнүүд аль нь вэ?
    A. Ордос, Түмэд, Урианхай
    B. Ордос, Түмэд, Юншээбү
    C. Түмэд, Халх, Юншээбү
    D. Халх, Ордос, Түмэд
    E. Түмэд, Урианхай, Халх
22. Юань улсын үед олон угсааны иргэдийг албанд хэрэглэх зэрэг дэвийг хэрхэн тогтоож байсан бэ? Дараах багананд буй зэрэг дэв болон угсаатны хамаарлыг тогтооно уу.
    1. I зэрэг — a. Монгол хүн
    2. II зэрэг — в. Умард хятадын хүн
    3. III зэрэг — c. Өмнөд хятадын хүн
    4. IV зэрэг — d. Өнгөт нүдтэн
    A. 1d, 2a, 3в, 4c
    B. 1в, 2c, 3a, 4d
    C. 1c, 2a, 3d, 4в
    D. 1a, 2в, 3c, 4d
    E. 1a, 2d, 3в, 4c
23. Монголчуудын зүгээс Манж чин улсад залгуулж байсан албанаас хамгийн хүнд хүчир алба юу байв?
    A. Цэргийн
    B. Харуулын
    C. Өртөөний
    D. Сүрэг адуулах
    E. Албан тарианы
24. Манжийн эрхшээлийн үед Ар Монголд анх хэзээ, хаана албаны сургууль байгуулагдсан бэ?
    A. 1709 онд Улиастай хотод
    B. 1760 онд Их хүрээнд
    C. 1776 онд Ховд хотод
    D. 1777 онд Сан бэйсийн хүрээнд
    E. 1802 онд Хар хорум хотод
25. Хошууг хэн толгойлж, тухайн хошууны аливаа хэргийг эрхлэн хариуцдаг байв?
    A. Засаг ноён
    B. Захирагч
    C. Мэйрэн
    D. Залан
    E. Занги
26. Тэнгэрийн тэтгэсэн хаан хүчтэй эсэргүүцсэнд хорсож Ойрад Монголын хүн ардыг хядан устгах тушаал өгчээ. Үүний уршгаар Ойрад Монголын хүн амын хэдэн хувь нь хядлагад өртөж, тэд жижигхэн угсаатны бүлгийн хэмжээнд хүртлээ цөөрсөн бэ?
    A. Дөрөвний хоёр нь
    B. Дөрөвний гурав нь
    C. Гуравны хоёр нь
    D. Дөрөвний хоёр нь
    E. Гуравны нэг нь
27. Манж жанжин, сайдын газар, аймаг, хошуудыг хооронд нь холбосон орон нутгийн өртөөдийг юу гэж нэрлэдэг байсан бэ?
    A. Цэрэгжүүлсэн өртөө
    B. Морин өртөө
    C. Буухиа өртөө
    D. Суман өртөө
    E. Суурь өртөө
28. XVII зууны эхэн үед Халх Монгол нь ямар засаг захиргааны зохион байгуулалттай байсан бэ?
    A. Аравт, зуут, мянгат
    B. Баг, сум, хошуу
    C. Зуут, мянгат, түмэн
    D. Отог, хошуу, аймаг
    E. Сум, хошуу, аймаг
29. Дараах 2 багананд бичигдсэн өгөгдлийн хоорондын хамаарлыг тогтооно уу.
    1. Ноёд язгууртнууд — a. Манжийн төрийн олон зүйлийн хүнд хүчир албанд зүтгэдэг цэрэг эр
    2. Суман эр — в. Аймаг хошууныхаа ноёд язгууртнуудын мэдэлд захирагдах харъяат ард
    3. Хамжлага ард — c. Манжийн захиргааны хэрэгт хүчин зүтгэдэг дээд давхрага
    4. Шавь нар — d. Хутагт хувилгаад, сүм хийдийн мэдэлд захирагдагсад
    A. 1d, 2c, 3a, 4в
    B. 1a, 2в, 3c, 4d
    C. 1в, 2a, 3d, 4c
    D. 1c, 2a, 3в, 4d
    E. 1a, 2d, 3a, 4c
30. Монгол уламжлалаар эцгийн гал голомтыг аль хөвгүүн нь өвлөн залгамжлах давуу эрхтэй вэ?
    A. Ахмад хүү
    B. Отгон хүү
    C. Аль ч хүү болно
    D. Эцгийн нэр заасан (гэрээсэлсэн) хүү
    E. Дунд хүү
31. Халх монголд байгуулагдсан буддын шашны анхны сүм хийд аль нь вэ?
    A. Гандан
    B. Заяын хийд
    C. Амарбаясгалант
    D. Ламын гэгээний хийд
    E. Эрдэнэ зуу
32. Монгол Оросын хилийн заагийг 1727 онд тогтоов. Ямар гэрээгээр зохицуулсан бэ?
    A. Хиагтын гэрээ
    B. Буурын гэрээ
    C. Гурван улсын гэрээ
    D. Нэрчүгийн гэрээ
    E. Манжийн хааны зарлигаар
33. Түүхэн сэдэвтэй бичигдсэн зохиол бүтээлүүдийн нэг нь “Хөх судар” түүхэн роман билээ. Энэ бүтээлийн зохиогч нь хэн бэ?
    A. Занабазар
    B. Д.Равжаа
    C. В.Инжинаш
    D. Намхайжамц
    E. Туульч Парчин
34. Монголын түүхэн сурвалж бичигт, “Худгийн усыг гаргагч, Хулгар тарвагаар зулам хийгч” хэмээн Улс төрийн бутралын үеийн зүүн Монголын нэгэн түмнийг магтсан байдаг. Энэ нь аль түмэн бэ?
    A. Халх түмэн
    B. Цахар түмэн
    C. Урианхай түмэн
    D. Ордос түмэн
    E. Түмэд түмэн

35. 1755 онд Манжийн эсрэг зэвсэгт тэмцэл хийхээр үгсэн тохиролцсон хүмүүс аль нь вэ?
A. Цэнгүнжав, Амарсанаа, Сэвдэнбалжир B. Банди, Саарал, Амарсанаа
C. Цэвдэнжав, Сэвдэнбалжир, Чингүнжав D. Чингүнжав, Амарсанаа, Сэвдэнбалжир
E. A ба C хариулт зөв
36. Богд хаант Монгол Улсын Засгийн газрын Дотоод яамны тэргүүн сайдад хэнийг тохоон томилсон бэ?
A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. Түшээ гүн Чагдаржав
D. Далай ван Гомбосүрэн E. Эрдэнэ ван Намсрай
37. Аль аль нь Манж чин улс "Шинэ засгийн бодлого"-ын хүрээнд шашны талаар авсан арга хэмжээ вэ?
1. Лам нарыг эхнэр авахыг зөвшөөрсөн
2. Лам нарыг цэргийн албанд татсан
3. Лам нарыг хар болохыг шаардах болсон
4. Лам нараас татвар авах болсон
5. Шавь нараас татвар авах болсон
A. 1, 3, 5 B. 2, 3, 4 C. 2, 4, 5 D. 2, 4, 5 E. 1, 2, 3
38. Хэзээ Жавзандамба хутагтыг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаанаар өргөмжлөх ёслол Их хүрээнд болсон бэ?
A. 1911.12.29-нд B. 1911.11.29-нд C. 1911.12.01-нд
D. 1911.12.30-нд E. 1911.12.4-нд
39. 1911 оны зун Богд уулын арын ой дотор хийсэн нууц зөвлөгөөнд Их хүрээний Эрдэнэ Шанзудбын яаманд хийсэн зөвлөгөөнд оролцсон Халхын дөрвөн аймаг, Их шавийн эрх мэдэл бүхий ноёд, лам нар бүрэн оролцсон уу.
A. Бүгдээрээ бүрэн оролцсон
B. Хөдөөнөөс ирсэн ноёд, лам нар оролцсон
C. Хүрээнд байсан ноёд лам нар оролцсон
D. Шинэ засгийн бодлогыг эсэргүүцсэн ноёд лам нар оролцсон
E. Манж хятадын дарлалыг эсэргүүцсэн ноёд лам нар оролцсон
40. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө Ерөнхий сайдын үүргийг хэн гүйцэтгэж байсан бэ?
A. Далай ван Гомбосүрэн B. Эрдэнэ ван Намсрай C. Чин ван Ханддорж
D. Да лам Цэрэнчимэд E. Түшээ гүн Чагдаржав
41. XIX–XX зууны зааг үеэр амьдарч байсан дараах алдарт туульчдын угсаа гарлыг тогтооно уу.
1. Сарьсан 2. Жилхэр 3. Парчин
a. Урианхай в. Дөрвөд c. Баяд d. Халх e. Захчин f. Өөлд
A. 1a, 2в, 3c B. 1в, 2c, 3e C. 1c, 2d, 3в
D. 1в, 2a, 3c E. 1f, 2e, 3a
42. Богд хаант Монгол Улсын Засгийн газрын Шүүх яамны тэргүүн сайдад хэнийг тохоон томилсон бэ?
A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. Түшээ гүн Чагдаржав
D. Далай ван Гомбосүрэн E. Эрдэнэ ван Намсрай
43. Манжийн "Шинэ засгийн бодлого"-ын зорилго юу байв?
A. Монгол орныг бүхэлд нь хөгжүүлэх
B. Монгол орны эдийн засгийг бэхжүүлэх
C. Монгол орны улс төр, эдийн засаг, соёлыг шинэчлэх
D. Монгол орныг хятадчилан нэгтгэх
E. Монгол орны нутаг дэвсгэрийг өөрийн түшиц болгох
44. Монгол улсын анхны ерөнхий сайд хэн бэ?
A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. Сайн ноён хан Намнансүрэн
D. Түшээ гүн Чагдаржав E. Шанзудба Бадамдорж
45. Манж Чин улсын ноёрхлыг түлхэн унагааж, шинэ тутам байгуулагдсан Монгол улс төрийн хэлбэрийн хувьд ямар улс байсан бэ?
A. Бүгд найрамдах улс B. Хэмжээт эрхт хаант улс C. Үндсэн хуульт хаант улс
D. Хэмжээгүй эрхт хаант улс E. B ба C хариулт зөв
46. Богд хаант Монгол улсын засгийн газраас 1912 онд нэгэн яамыг шинээр нэмэн байгуулсан бөгөөд энэ нь ямар Яам байсан бэ?
A. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам
B. Гадаад хэргийг эрхлэн шийтгэгч яам
C. Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам
D. Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам
E. Гаалийн хэргийг эрхлэн шийтгэх яам

47. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920 оны 06-р сарын 25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ?
    A. Хоёр бүлгэмийг нэгтгэн МАН-ыг байгуулсан
    B. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон
    C. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн
    D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн
    E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн
48. ЗОУ-аас тусламж хүсэхээр Эрхүүд очсон Ардын намын анхны долоо тэнд ажил үүргээ хуваарилж нэг хэсэг нь Зөвлөлт засгийн газрын удирдлагатай уулзаж тусламжийн хэргийг бүтээхээр Омск, Москва явахаар болсон билээ. Хэн хэн энэ ажилд хуваарилагдсан бэ?
    A. С.Данзан, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан
    B. Д.Чагдаржав, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан
    C. Д.Лосол, Д.Бодоо, С.Данзан
    D. С.Данзан, Д.Чагдаржав, Д.Лосол
    E. Д.Чагдаржав, Х.Чойбалсан, Д.Лосол
49. Ардын журамт цэргийн анхны 4 хороон даргад хэн хэн томилогдсон бэ?
    A. Ч.Базарсад, Б.Пунцаг, Д.Сүхбаатар, Ц.Хасбаатар
    B. Б.Пунцаг, Ц.Дамбадорж, Ц.Хасбаатар, О.Цэрэндорж
    C. Д.Сүхбаатар, Ч.Базарсад, Б.Пунцаг, О.Цэрэндорж
    D. Ц.Хасбаатар, Ц.Дамбадорж, Б.Пунцаг, О.Цэрэндорж
    E. Б.Пунцаг, О.Цэрэндорж, Ц.Хасбаатар, Ч.Базарсад
50. 1945 оны чөлөөлөх дайнд онц гарамгай тулалдаж, зориг баатарлагийн жишээ үзүүлж, БНМАУ-ын баатар цол хүртсэн хүмүүс хэн бэ?
    A. Дандар, Дүүдэй, Дампил
    B. Олвой, Аюуш, Данзанваанчиг
    C. Аюуш, Данзанваанчиг, Дүүдэй
    D. М.Экей, Аюуш, Дампил
    E. Л.Гэлэгбаатар, Чогдон, Дандар
51. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу.

| | |
|---|---|
| A. Тайж | 1. Боржигон овгийн бус язгуууртны толгойлогч |
| B. Хохь тайж | 2. Хаан ширээг залгамжлах хүүг |
| C. Залан | 3. Албат хамжлагагүй, хөрөнгө хогшил багатай |
| D. Хунтайж | 4. Цэргийн хэргийг голчлон эрхлэнэ. Хошууны дөрвөн түшмэлийн нэг |
| E. Тайш | 5. Чингис хааны удмын үр ачийг |

    A. A2, B3, C4, D1, E5
    B. A1, B4, C3, D2, E5
    C. A1, B3, C4, D5, E2
    D. A5, B3, C4, D2, E1
    E. A1, B3, C4, D2, E5
52. Эцэг, хүү, ач, гучийн холбоотон аль нь вэ? Зөв хариуг сонгоно уу.
    A. Чингис, Өгөдэй, Хубилай, Чингим
    B. Чингис, Тулуй, Хубилай, Чингим
    C. Чингис, Тулуй, Аригбөх, Чингим
    D. Тэмүжин, Өгөдэй, Хубилай, Аригбөх
    E. Тэмүжин, Тулуй, Аригбөх, Хубилай
53. 1084 онд Хамаг Монголын нэр түүхэн сурвалжид анх удаа тэмдэглэгджээ. Энэхүү Хамаг Монголын нэр түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн оныг зууны тоололд шилжүүлнэ үү.
    A. X зуун
    B. XI зуун
    C. X зууны II хагас
    D. XI зууны II хагас
    E. XII зууны II хагас
54. XVII зууны I хагаст буюу ...........о нд ............... үсгийг .................. зохиожээ. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.
    A. Али гали – 1587 – Аюуш гүүш
    B. Дөрвөлжин – 1269 - Чойжи-Одсэр
    C. Тод – 1648 – Зая бандид Намхайжамц
    D. Соёмбо – 1686 – Өндөр гэгээн Занабазар
    E. Дөрвөлжин – 1269 – Пагва лам

## ХУВИЛБАР C

1. Археологийн сүүлийн үеийн судалгаагаар Монгол нутагт хэдий үеэс хүн амьдарч эхэлсэн нь тогтоогдсон бэ?
    A. 800 мянган жилийн тэртээгээс
    B. Нэг сая жилийн тэртээгээс
    C. 500 мянган жилийн тэртээгээс
    D. 300 мянган жилийн тэртээгээс
    E. Нэг сая 500 мянган жилийн тэртээгээс
2. Баянхонгор аймгийн Нарийн гол /Уранхайрханы/-ын дурсгал аль үеийн гол дурсгал вэ?
    A. Хуучин чулуун зэвсэг
    B. Дунд чулуун зэвсэг
    C. Хүрэл зэвсгийн үе
    D. Төмөр зэвсгийн түрүү үе
    E. Хүннү

3. Хаанаас 12 км урт, 8 км өргөн талбай бүхий чулуун зэвсгийн дархны газар илэрсэн бэ?
   A. Арц богд B. Баянзаг C. Рашаан хад
   D. Тамсагбулаг E. Цагаан агуй
4. Хэдий үед оюун ухаант хүн бий болсон бэ?
   A. 800 000 жилийн тэртээ B. 100 000 жилийн тэртээ
   C. 40 000 жилийн тэртээ D. 15 000 жилийн тэртээ
   E. 8 000 жилийн тэртээ
5. Монгол нутагт өргөн тархсан дөрвөлжин булш нь аль үед хамаарагдах дурсгал вэ?
   A. Хуучин чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг
   C. Шинэ чулуун зэвсэг D. Хүрэл, төмөр зэвсгийн үе
   E. Хүннү
6. Аль нь Хүннү нарын уугуул нутаг вэ?
   A. Цагаан хэрмээс Байгаль нуур, Солонгосын хойгоос Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв
   B. Хянганы нуруугаар төвлөрч, Шар мөрнөөс Эргүнэ мөрөн, Дорнодын талаас Ляохэ голын эх хүрч байв
   C. Хангайн нуруугаар төвлөрөн Их элсэн говиос Байгаль нуур, Хянганы нуруунаас Алтайн нуруу хүрч байв
   D. Ордосоос Байгаль нуур өнгөрч, Алтайн нуруунаас Дорнодын тал хүрч байв
   E. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх уудам нутагт оршин тогтнож байв
7. Аль улс нь бурхны шашныг төрийн шашны хэмжээнд хүртэл дээдэлж, дэлгэрүүлсэн бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
8. Аль нь Сяньбийн даргай нум бэ?
   A. Хус мод, үхрийн эврээр зүйж, нааж хийсэн нум
   B. 140 см-ийн урттай нум
   C. Яс, хус модны 7-11 хэсгийг эвлүүлж нааж хийсэн нум
   D. Сум нь тухайн үед хэрэглэж байсан нумнаас хоёр дахин хол тусдаг нум
   E. Сум нь тухайн үед хэрэглэж байсан нумнаас гурав дахин хол тусдаг нум
9. Аль нь нутаг дэвсгэр, хил хязгаарын бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолоо Хан улсаар хүлээн зөвшөөрүүлсэн бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
10. Монголын эрдэмтдээс хэн нь Хүннүгийн талаар хамгийн дорвитой судалгаа хийсэн бэ?
   A. Н.Сэр- Оджав B. Х.Пэрлээ C. Ц.Доржсүрэн
   D. Г.Сүхбаатар E. Н.Ишжамц
11. Эргүнэ гүнийн домгийн гол агуулга юу вэ?
   A. Алунгоо таван хүүдээ алдарт сургаалаа хэлсэн тухай
   B. Ах дүү хоёр муудалцан ах нь аймаг олноо дагуулан нүүж Тогон улсыг байгуулсан тухай
   C. Түрэг Монгол аймгуудын хоорондох нэгэн удаагийн дайнд Монголчууд ялагдаж алс бөглүү газар очиж суусан тухай
   D. Бөртө чину, Гоо марал хоёр тэнгис далайг гэтлэн нүүж ирсэн тухай
   E. Алагдах дайсангүй энх амгалангийн орон Эргүнэ-Гүн болох тухай
12. Хамаг Монголын ханлигийн эхний гурван хангуудын хан суусан цаг хугацааны дараалтыг ол.
   A. Хабул, Хотула, Амбагай B. Хабул, Амбагай, Хотула
   C. Хотула, Хабул, Амбагай D. Амбагай, Хабул, Хотула
   E. Хотула, Амбагай, Хабул
13. Дараах зүтгэлтнүүдийн хэн нь Чингис хааны "Дөрвөн нохос"-т багтах вэ?
   A. Боорчу, Мухулай, Борохул, Чулуун B. Хар хиргүэ, Чуу мэргэн, Шихихутаг, Сорхон шар
   C. Чулуун, Чимбай, Зургаадай, Зэв D. Зэв, Чулуун, Чимбай, Мухулай
   E. Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбээдэй
14. Их Монгол улсын төрийн гол шүтлэг аль нь вэ?
   A. Бөө мөргөл B. Шарын шашин C. Улааны шашин
   D. Христосын шашин E. Бүгдийг тэгш үзэж байсан
15. Лу. Алтан товчид тэмдэглэснээр Тэмүжин хэзээ төрсөн бэ?
   A. Хар усан бар жилийн зуны эхэн сарын арван долооны бар цагт
   B. Хар усан луу жилийн зуны дунд сарын арван тавны луу цагт
   C. Хар усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургааны морин цагт
   D. Хар усан нохой жилийн зуны адаг сарын арван есний нохой цагт
   E. Алтан гахай жилийн намрын дунд сарын арван долооны гахай цагт

16. Хэн хэн Тэмүжинг дэмжиж Хамаг Монголын хаанд өргөмжилсөн бэ?
    A. Алтан, Хучар, Тогтоа бэхи
    B. Алтан, Хучар, Жамуха, Тайчу
    C. Алтан, Хучар, Сачи бэхи
    D. Алтан, Хучар, Тоорил
    E. Алтан, Хучар, Тоорил, Сэнгүм
17. Монгол бичгийн хамгийн эртний дурсгал аль нь вэ?
    A. Мөнх хааны гэрэлт хөшөө
    B. Чингисийн чулууны бичиг
    C. Цогтын хадны бичиг
    D. Алтан товч
    E. Монголын нууц товчоо
18. Чингис хааны төрийн 4 их хатны төрсөн аймгийг зөв харгалзуул.
    1. Бөртэ — a. Хонгирад
    2. Хулан — b. Татар
    3. Есүй — c. Мэргид
    4. Есүгэн — d. Хэрэйд
    A. 1d 2a 3b 4c
    B. 1d 2c 3a 4b
    C. 1a 2c 3b 4b
    D. 1b 2d 3a 4c
    E. Зөв хариулт байхгүй
19. Чингис хааны дархадыг нэрлэнэ үү.
    A. Борохул, Боорчи, Мухулай, Чулуун
    B. Зэлмэ, Зэв, Борохул, Мухулай, Шихихутаг
    C. Зэв, Боорчи, Мухулай, Шихихутаг
    D. Борохул, Зэлмэ, Боорчи, Сорхон шар
    E. Шихихутаг, Мухулай, Борохул, Зэлмэ
20. Бурхны шашны хөлгөн судар 108 боть Ганжуурыг 33 эрдэмтнээр орчуулуулж, алтан үсгээр бичүүлэн залж төрийн гурван эрдэнийн нэг болгосон хаан хэн бэ?
    A. Цогт хунтайж
    B. Түмдийн Алтан хаан
    C. Түмэн засагт хаан
    D. Цахарын Лигдэн хаан
    E. Автай сайн хаан
21. Хэн, хэзээ Эрдэнэ зуу хийдийг байгуулсан бэ?
    A. 1271 онд Хубилай хаан
    B. 1586 онд Автай сайн хаан
    C. 1577 онд Алтан хаан
    D. 159 онд Түмэн засагт хаан
    E. 1513 онд Батмөнх даян хаан
22. Аль үеийг түүхэн сурвалжид “Гар газар, хөл хөсөр” байсан үе хэмээн тэмдэглэдэг вэ?
    A. Алтан хааны үеийг
    B. Бага хаадын үеийг
    C. Улс төрийн бутралын үеийг
    D. Батмөнх даян хааны үеийг
    E. Түмэн Засагт хааны үеийг
23. Жинжлэгээс Ил хүртэл байрлаж байсан 50 суурь харуулд дан биеэр очиж хаадаг хилийн харуулын албыг юу гэж нэрлэдэг байсан бэ?
    A. Гэр харуул
    B. Дотоод харуул
    C. Суман харуул
    D. Суурь харуул
    E. Цэргийн харуул
24. Хаана Манж нар цэргийн хэрэгцээнд зориулан Монголчуудаар тариалангийн алба гүйцэтгүүлдэг байсан бэ?
    A. Улиастайд
    B. Улаангомд
    C. Ховдод
    D. Туулын адагт
    E. Халх гол хавьд
25. Манжийн элч, түшмэд, албан бичиг, зэргийг яаралтай нэвтрүүлэн хүргэх зориулалттай цэрэгжүүлсэн морин өртөөг юу гэж нэрлэдэг байв.
    A. Цэрэгжүүлсэн өртөө
    B. Морин өртөө
    C. Буухиа өртөө
    D. Суман өртөө
    E. Суурь өртөө
26. Нутгийн дотор байгуулсан харуулын албанд алба хаахыг ямар харуул гэж нэрлэдэг байсан бэ?
    A. Гэр харуул
    B. Дотоод харуул
    C. Суман харуул
    D. Суурь харуул
    E. Цэргийн харуул
27. Батмөнх Даян хаан хөвгүүддээ эзэмшил нутаг хуваaж өгснөөр түүний үр ач нарын үеэс Халх түмэн нь дотроо ямар гурван аймаг болон хуваагдсан бэ?
    A. Сэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан
    B. Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан
    C. Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан
    D. Засагт хан, Сайн ноён хан, Сэцэн хан
    E. Сайн ноён хан, Түшээт хан, Сэцэн хан
28. XVII зууны эхэн үед Халх Монгол засаг захиргааны ямар зохион байгуулалттай байсан бэ?
    A. Аравт, зуут, мянгат
    B. Баг, сум, хошуу
    C. Зуут, мянгат, түмэн
    D. Отог, хошуу, аймаг
    E. Сум, хошуу, аймаг
29. Манжийн эрхшээлийн үеийн суман харуулын 1 цэрэг, захирагч түшмэл, тайж, хөтөл нар тухайн үеийнхээ ханшаар жилд хэр хэмжээний зардал хэрэглэж байсан бэ?
    1. Цэрэг — a. 40 лан
    2. Захирагч түшмэл — в. 50 лан
    3. Тайж — c. 10 лан
    4. Хөтөл

A. 1c, 2в, 3a, 4c B. 1в, 2a, 3c, 4a C. 1c, 2в, 3c, 4a
D. 1a, 2в, 3в, 4c E. 1a, 2a, 3c, 4a

30. Юань улсын сүүлчийн хаан хэн бэ?
A. Тогоонтөмөр B. Лигдэн C. Аюушридар
D. Есөнтөмөр C. Хайсанхүлэг

31. Манжийн хааны "Төмөр сүрэг" төвлөрч байсан гол нутгийг ол.
A. Дарьганга B. Хүрээ C. Улиастай
D. Ховд E. Төмөр сүрэг гэж байгаагүй

32. Юань гүрний төрийн дээд байгууллагыг нэрлэнэ үү.
A. Цэргийн яам B. Түшмэлийн яам C. Дотоод бичгийн яам
D. Нууц бичгийн яам E. Дэвшүүлэх, бууруулах яам

33. Хубилай хаан Монгол гүрний нийслэлийг Хятадад албан ёсоор шилжүүлэн, улсынхаа нэрийг "Юан" гэж өөрчилсөн он цаг аль нь вэ?
A. 1260 он B. 1264 он C. 1269 он D. 1271 он E. 1281 он

34. Амарсанаа тэргүүтэй Зүүнгарын босогчид Манжийн цэрэгтэй хийсэн хамгийн сүүлчийн том тулаан ямар нэртэй газар болсон бэ?
A. Цэцэг нуур B. Шарбэл C. Толбо нуур D. Улаан бураа E. Шишгид

35. Аль нь Манж чин улсын "Шинэ засгийн бодлого"-ын хүрээнд шашны талаар баримталсан бодлого вэ?
A. Шарын шашныг улам бүр дэмжин тэтгэх болсон
B. Шарын шашныг дэмжин тэтгэх бодлогоосоо ухарсан
C. Улааны шашныг дэмжих бодлого барьсан
D. Монголын бөөгийн мөргөлийг сэргээхийг оролдсон
E. Христосын шашныг дэмжих бодлого барьсан

36. Хэзээ цаг хугацаа заан тулган шаардаж Сандо амбаныг хөөн гаргаснаар Их хүрээнд Манжийн төрийн ноёрхол унав?
A. 1911.12.29-нд B. 1911.11.30-нд C. 1911.12.01-нд
D. 1911.12.4-нд E. 1911.12.5-нд

37. 1911 оны зун Халхын дөрвөн аймаг, Их шавийн эрх мэдэл бүхий ноёд, лам нар Жавзандамба хутагтад "бат оршил" өргөх үеэр Их хүрээний Эрдэнэ Шанзудбын яаманд хийж байсан зөвлөлгөөнөө яагаад Богд уулын арын ой дотор үргэлжлүүлэх болсон бэ?
A. Эрдэнэ Шанзудбын яам хөл хөдөлгөөнтэй байсан тул
B. Эрдэнэ Шанзудбаас болгоомжилж
C. Манж амбангаас болгоомжилж
D. Хоорондоо санал зөрөлдсөний улмаас
E. Тав тухтай ярилцахын тулд

38. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө Ерөнхий сайдын үүргийг ямар яамны сайд гүйцэтгэж байсан бэ?
A. Дотоод B. Гадаад C. Сангийн D. Шүүх E. Цэргийн

39. 1911 оны зун тусламж эрж очсон Монголын төлөөлөгчдөд Орос улсын эрх баригчид юу амласан бэ?
1. Монголд хийж байгаа шинэтгэлийг болиулах талаар Бээжинд шахалт үзүүлнэ
2. Монголын тусгаарлах хөдөлгөөнд зэр зэвсгийн болон мөнгөн тусламж үзүүлнэ
3. Пулемёт буу бүхий 2000 казах (хасаг) цэргээр тусална
4. Хятадаас монголчуудын эсрэг хийж болзошгүй аллага хядлагаас өмгөөлнө
5. Их хүрээн дэх консулын газраа харгалзах цагдаагийн хүчийг цэргээр зузаатгана
A. 2, 3, 5 B. 1, 2, 4 C. 2, 3, 4 D. 1, 4, 5 E. 2, 4, 5

40. Үйл явдал, он цагийн хамаарлыг тогтооно уу.

| | |
|---|---|
| 1. Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар байгуулагдав | a. 1911.11.30 |
| 2. Хүрээнд сууж байсан манж амбан Сандо нутаг буцав | в. 1911.12.04 |
| 3. Ховд хот Манж, Хятад цэргээс чөлөөлөгдөв | c. 1911.12.29 |
| 4. Улиастай хот Манж, Хятад цэргээс чөлөөлөгдөв | d. 1912.08.07 |
| 5. Богд хаант Монгол улс байгуулагдав | e. 1912.01.21 |

A. 1a, 2в, 3d, 4c, 5e B. 1d, 2a, 3в, 4c, 5e C. 1a, 2в, 3d, 4e, 5c
D. 1в, 2a, 3e, 4d, 5c E. 1d, 2в, 3a, 4c, 5d

41. XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед Хятад худалдаачид өртэй хүмүүс өрөө төлж чадахгүй болоход түүнд тусламж болгон 50 лан өгч байжээ. Тэр тусламжийн эцсийн зорилго юу байв?
A. Өсгөн үржүүлэх замаар өрөө төлөх боломж олгох B. Өрөө төлүүлж авахын тулд ая тал засах
C. Худалдаа хийлгэх D. Сэтгэл санааны дэм өгөх
E. Нийт хошуугаар нь өсгөн нэмэгдүүлж төлүүлэх

42. Богд хааны зарлигаар байгуулагдсан Богд хаант Монгол улсын засгийн газрын анхны 5 яам аль нь вэ?

| | |
|---|---|
| 1. Дотоод яам | A. 1, 2, 3, 4, 5 |
| 2. Гадаад яам | B. 1, 2, 3, 4, 6 |
| 3. Гаалийн яам | C. 1, 2, 3, 5, 6 |
| 4. Сангийн яам | D. 1, 2, 4, 5, 6 |
| 5. Шүүх яам | E. 1, 2, 3, 5, 6 |
| 6. Цэргийн яам | |

43. 1911 оны зун Богд уулын арын ой дотор хийсэн нууц зөвлөгөөнөөс Орос улсаас тусламж эрэх төлөөлөгчөөр хэн хэнийг сонгон томилсон бэ?
   A. Чин ван Ханддорж, Эрдэнэ Шанзудба Бадамдож, Түшмэл Хайсан
   B. Да лам Цэрэнчимэд, Чин ван Ханддорж, лам Чагдаржав
   C. Түшмэл Хайсан, Эрдэнэ Шанзудба Бадамдож, түшмэл Цэдэвсүрэн
   D. Чин ван Хандорж, Эрдэнэ Шанзудба Бадамдож, Түшмэл Хайсан
   E. Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, түшмэл Хайсан
44. 1913 оны сүүл, 1914 оны эхээр Монгол улсын ерөнхий сайд Т.Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчдийн Орос улсад айлчилсан зорилго юу байсан бэ?
   A. 1913 оны Орос-Хятадын гэрээг цуцлуулах
   B. Өвөр Монголыг нэгтгэхэд дэмжлэг авах, мөнгө зээлэх
   C. Гуравдагч улстай холбоо тогтоход дэмжлэг авах
   D. A. B зөв
   E. Бүгд зөв
45. Богдын засгийн газар 1913 онд таван замын цэргийг илгээн, цэргийн жанжнаар манлай баатар Дамдинсүрэнг томилжээ. Таван замын цэргийн гол зорилго юу вэ?
   A. Олноо өргөгдсөн Монгол улсын хилийг хамгаалах
   B. Олноо өргөгдсөн Молнгол улсын хилд халдан ирсэн Хятад цэрэгтэй байлдах
   C. Өвөр Монголыг чөлөөлөх
   D. Ховд хот, Ховдын хязгаарыг чөлөөлөх
   E. A ба B хариулт зөв
46. Монгол оронд цагаан цэрэг удирдан орж ирсэн хүмүүсийн нэрийг дурьдахдаа хамааралгүй хүн оруулсан гэвэл аль нь вэ?
   A. Кайгородов B. Бакич C. Байкалов D. Казанцев E. Резухин
47. Хэн хэн ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчөөр томилогдсон ардын намын анхны долоод багтсан бэ?
   A. Д.Бодоо, Ө.Дэндэв B. Д.Чагдаржав, М.Дугаржав
   C. С.Данзан, Х.Чойбалсан D. Д.Сүхбаатар, С.Жамъян
   E. Д.Догсом, А.Жигмиддорж
48. Алтайн урианхайн Саруул гүний хошууны нутаг, Толбо нуурын бүслэлт хэзээ эхлэж, хэд хоног үргэлжилсэн бэ?
   A. 1921 оны 8-р сарын эхээр эхлэж, 40 хоног үргэлжилсэн
   B. 1921 оны 8-р сарын дунд үеэс эхлэж, 42 хоног үргэлжилсэн
   C. 1921 оны 9-р сарын эхээр эхлэж, 41 хоног үргэлжилсэн
   D. 1921 оны 9-р сарын дунд үеэс эхлэж, 42 хоног үргэлжилсэн
   E. 1921 оны 9-р сарын эцсээр эхлэж, 45 хоног үргэлжилсэн
49. ЗОУ-аас тусламж хүсэхээр Эрхүүд очсон Ардын намын анхны долоо тэнд ажил үүргээ хуваарилж нэг хэсэг нь хоёр талтай харилцах, цэргийн хэрэгт боловсрох зэрэг үүрэгтэйгээр Эрхүүд үлдэж ажиллах болсон. Хэн хэнд энэ үүрэг оногдсон бэ?
   A. С.Данзан, Д.Бодоо B. Д.Сүхбаатар, Д.Чагдаржав C. Х.Чойбалсан, Д.Бодоо
   D. Д.Сүхбаатар, Х.Чойбалсан E. Д.Догсом, Х.Чойбалсан
50. 1921 оны хувьсгал агуулга, шинж чанараараа ямар хувьсгал байсан бэ?
   A. Ардын ардчилсан B. Үндэсний C. Хөрөнгөтний ардчилсан
   D. Үндэсний ардчилсан E. Ардчилсан
51. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу.

| | |
|---|---|
| A. Хүрээ | 1. Шавь нарын засаг захиргааны үндсэн нэгж |
| B. Сум | 2. Цэрэг-захиргааны хосолсон үндсэн нэгж |
| C. Хошуу | 3. Нэг гарал бүхий овгуудын нэгдэл байсан бол XVII зууны үеэс засаг захиргааны том нэгж болсон. |
| D. Аймаг | 4. Манж нар монголчуудыг эзэлсэний дараа бий болгосон засаг захиргааны нэгж |
| E. Отог | 5. Овгууд бэлчээр сонгож бөөнөөрөө нүүж, суух |

   A. A5, B4, C2, D1, E3 B. A4, B5, C2, D1, E3 C. A1, B4, C5, D1, E3
   D. A4, B5, C3, D1, E2 E. A5, B4, C2, D3, E1

52. Чингис хаан хар усан морин жил буюу 1162 онд Ононы Дэлүүн болдогт төржээ. Чингис хааны төрсөн оныг зууны тоололд шилжүүлнэ үү.
    A. XI зуун  B. XII зуун  C. XI зууны II хагас
    D. XII зууны II хагас  E. XIII зууны II хагас
53. XVI зууны II хагаст буюу . …………онд…………….. үсгийг ……………… зохиожээ. (Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу)
    A. Али гали – 1587 – Аюуш гүүш  B. Дөрвөлжин – 1269 - Чойжи-Одсэр
    C. Тод – 1648 – Зая бандид Намхайжамц  D. Соёмбо – 1686 – Өндөр гэгээн Занабазар
    E. Дөрвөлжин – 1269 – Пагва лам
54. Эцэг, хүү, ач, гучийн холбоотон аль нь вэ? Зөв хариуг сонгоно уу.
    A. Есүхэй, Чингис, Зүчи, Хүлэгү  B. Есүхэй, Тэмүжин, Тулуй, Хүлэгү
    C. Есүхэй, Тэмүжин, Цагаадай, Хүлэгү  D. Есүхэй, Тэмүжин, Аригбөх, Гүюг
    E. Есүхэй, Тэмүжин, Тулуй, Гүюг

## ХУВИЛБАР D

1. Дундговь аймгийн Гурвансайханы Ярхын дурсгал аль үеийн гол дурсгал вэ?
    A. Хуучин чулуун зэвсэг  B. Дунд чулуун зэвсэг  C. Хүрэл зэвсгийн үе
    D. Төмөр зэвсгийн түрүү үе  E. Хүннү
2. Дараах дурсгалуудын аль нь Монгол нутаг дахь хамгийн эртний урлагийн дурсгал вэ?
    A. Баянхонгор аймаг Баянлиг сум Цагаан агуйн дурсгал
    B. Ховд аймаг Манхан сум Хойд цэнхэрийн агуйн зураг
    C. Дорнод аймгийн Булган сум Норовлингийн суурин
    D. Булган аймгийн Хутаг-Өндөр сум Холтост нугын дөрвөлжин булш
    E. Завхан аймгийн Шилүүстэй сум Дааган дэл уулын буган хөшөө
3. Хэдий үед хүн гал гаргаж авсан бэ?
    A. Доод палеолитын үед  B. Дунд палеолитын үед  C. Дээд палеолитын үед
    D. Мезолитын үед  E. Неолитын үед
4. Дараах зургуудын аль нь Монгол нутгаас олдсон хамгийн эртний үед холбогдох зосон зураг вэ?
    A. Ишгэн толгойн хадны зураг  B. Чандмань хар үзүүрийн хадны зураг
    C. Хад үзүүрийн хадны зураг  D. Хойд цэнхэрийн агуйн зураг
    E. Рашаан хадны зураг
5. Монгол нутагт өргөн тархсан хадны сүг зургийг үйлдсэн аргаар нь юу гэж ангилдаг вэ?
    A. Зураасан ба цохимол  B. Зураасан ба сийлмэл
    C. Сийлмэл ба цохимол  D. Зурмал ба зураасан
    E. Зосон ба сийлмэл
6. Аль нь Сяньби нарын уугуул нутаг вэ?
    A. Цагаан хэрмээс Байгаль нуур, Солонгосын хойгоос Ил тарвагатай хүртэлх нутагт оршиж байв
    B. Ордосоос Байгаль нуур өнгөрч, Алтайн нуруунаас Дорнодын тал хүрч байв
    C. Хангайн нуруугаар төвлөрөн Их элсэн говиос Байгаль нуур, Хянганы нуруунаас Алтайн нуруу хүрч байв
    D. Хянганы нуруугаар төвлөрч, Шар мөрнөөс Эргүнэ мөрөн, Дорнодын талаас Ляохэ голын эх хүрч байв
    E. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх уудам нутагт оршин тогтнож байв
7. Хүннүчүүд нас барагсдаа хэрхэн оршуулдаг байсан бэ?
    A. Чулуун хашлагатай бунханд, ихэвчлэн ил тавьж, мал дагалдуулан
    B. Шороон хашлагатай бунханд, эсгийнд ороож, морь дагалдуулан
    C. Дүнзэн хашлагатай бунханд, ихэвчлэн модон австай тавьж, хэрэглэж байсан зүйлсийг нь дагалдуулан
    D. Төмөр хашлагатай бунханд, арьсанд ороож, ширдэг дагалдуулан
    E. Шарилыг нь хатааж, тахилын сүм барьж, хөргийг нь залж, дайны олзноос дагалдуулан
8. Аль нь Сяньби улсын цэрэг вэ?
    A. Даргай нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
    B. Хатуу нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
    C. Нум сумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
    D. Төмөр жадаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
    E. Хүнд морин цэрэг

9. Эртний улсуудаас аль нь газар тариалан арай түлхүү эрхэлдэг байсан бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
10. Юуг эртний улсууд гадагш нь бараг худалдаалдаггүй байв?
   A. Морийг B. Ноос ноолуурыг C. Арьс ширийг
   D. Ангийн үсийг E. Байгалийн баялагийг
11. Аль улсын булшнаас ясан хэл хуур хөгжим олдсон бэ?
   A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг E. Уйгур
12. XI-XII зууны үед язгуурын монгол аймгууд Нирун ба Дарлигин гэсэн хоёр бүлэгт хуваагддаг байжээ. Дарлигин аймгууд гэж ямар овог аймгийг хэлдэг байсан бэ?
   A. Добу мэргэний бэлбэсэн хатан Алунгоогийн гурван хөвгүүдийн удмаас үүсэлтэй ноёлогч овог аймгууд
   B. Эргүнэ гүнд очсон Нукуз, Хиян хоёр овгоос үржин олон болсон Эргүнэ гүний монгол аймгууд
   C. Хамаг монголоос бусад ханлиг аймгууд
   D. Хамаг монгол ханлигийн бүрэлдэхүүнд багтдаг бүх овог аймгууд
   E. Хабул ханы удмынхан
13. XI-XII зууны үеийн Гурван Мэргидийн гол төвлөрөн нутаглаж байсан газар хаагуур байсан бэ?
   A. Онон мөрний хөндий, Сэлэнгийн эхээр B. Орхон Туулын хөндий
   C. Гурван голын сав D. Хангай, Хэнтийн нурууны хооронд
   E. Орхон голын адаг, Сэлэнгэ мөрний дунд биеэр
14. "Монголын нууц товчоо"-нд, "... Чамайг, Ухаан санааг чинь голоогүй, Үзэсгэлэн гоог чинь голоогүй … Хагацсан улсыг хамтатгасны, Бутарсан улсыг бүрэн болгосны тусых нь төрийн үйлийг санаж" хэмээн хэн гэдэг хатнаа, хэнд өгсөн хэмээн өгүүлдэг вэ?
   A. Хулан гоо хатнаа Баарины Наяа ноёнд B. Сорхагтан бэхич хатнаа Мангудын Хуйлдар сэцэнд
   C. Ибаги бэхич хатнаа Уруудын Жорчидайд D. Гүрбэлжин гоо хатнаа Сөнидийн Гилгүдэй баатарт
   E. Есүй хатнаа Аралудын хүлэг Боорчуд
15. Монголын түүхийн талаарх сурвалжуудыг зөв харгалзуул.
   1. Марко Поло a. Судрын чуулган
   2. П.Карпини b. Дорно этгээдэд зорчсон минь
   3. Г.Рубрук c. Монголчуудын түүх
   4. Рашид ад Дин d. Орчлонгийн элдэв сонин
   A. 1d 2c 3b 4a B. 1a 2d 3b 4c C. 1a 2c 3b 4d
   D. 1c 2b 3d 4a E. 1c 2b 3d 4a
16. Хабул хан амьд ахуйдаа өөрийн залгамжлагчаар хэнийг гэрээсэлсэн бэ?
   A. Өөрийн хүү Хотулаг B. Тайчуудын Амбагайг C. Хүү Охинбархагыгаа
   D. Хүү Бартанбаатарыг E. Ач хүү Есүхэй баатарыг
17. Аль нь Хамаг Монгол улсын хаадын зөв дараалал вэ?
   A. Хабул, Амбагай, Хотула, Есүхэйбаатар B. Хабул, Амбагай, Хотула, Тэмүжин
   C. Хабул, Амбагай, Хадаан, Есүхэйбаатар D. Хабул, Хотула, Хадаан, Есүхэйбаатар
   E. Хабул, Амбагай, Хотула, Есүхэйбаатар, Тэмүүжин
18. Тэмүжинд Чингис хаан цолыг хэзээ, хаана, юуны учир өгсөн бэ?
   A. 1162 онд Хэрлэний Хөдөө аралд гартаа нөж атгаж төрсөн тул
   B. 1189 онд Хар зүрхэний Хөх нуурт Хамаг Монголын хаан болсон тул
   C. 1190 онд Далан Балжудад 13 хүрээний байлдаанд ялсан тул
   D. 1206 онд Онон мөрний эхэнд Их Монгол улсын хаан болсон тул
   E. 1196 онд Улзын голд Мэгүжин сүүлтийг бут цохисон тул
19. Чингис хааныг таалал болсны хойно түүний үр ач нар хаан ширээний төлөөх тэмцэлд хэрхэн хуваагдсан бэ?
   A. Зүчи – Цагаадайн угсаа ба Өгөдэй – Тулуйн угсаа
   B. Зүчи - Өгөдэйн угсаа ба Цагаадай – Тулуйн угсаа
   C. Зүчи – Тулуйн угсаа ба Өгөдэй – Цагаадайн угсаа
   D. Өгөдэйн угсаа ба Зүч - Цагаадай – Тулуйн угсаа
   E. Тулуйн угсаа ба Зүчи, Цагаадай, Өгөдэйн угсаа
20. Хэн, хэзээ Төвдийн Содномжамцад "Далай лам" цол олгосон бэ?
   A. 1271 онд Хубилай B. 1577 онд Алтан хаан C. 1586 онд Автай сайн хаан
   D. 1590 онд Түмэн засагт хаан E. 1513 онд Батмөнх даян хан
21. Батмөнх Даян хаан хөвгүүддээ эзэмшил нутаг хувааж өгснөөр түүний үр ач нарын үеэс Халх түмэн нь дотроо ямар гурван аймаг болон хуваагдсан бэ?
   A. Сэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан B. Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан
   C. Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан D. Засагт хан, Сайн ноён хан, Сэцэн хан
   E. Сайн ноён хан, Түшээт хан, Сэцэн хан

22. 1640 онд Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Халх, Ойрад, Хөх нуур, Ижил мөрний Монголчуудыг төлөөлсөн том ноёдын чуулган болсон. Чуулганы гол үр дүнг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ?
    A. Монгол Ойрадын их цаазыг баталсан
    B. Халх журам хуулийг баталсан
    C. Түшээт хан, Засагт ханы ноёдыг хооронд нь эвлэрүүлсэн
    D. Халх, Ойрад хоёр бие даасан улс болохоо харилцан хүлээн зөвшөөрсөн
    E. Манжид дагаар орох шийдвэр гаргасан
23. Жинжлэгээс Манжуур хүртэл байрлах 59 харуулд гэр оронтойгоо очиж гүйцэтгэдэг харуулын албыг юу гэж нэрлэдэг байсан бэ?
    A. Гэр харуул B. Дотоод харуул C. Суман харуул
    D. Суурь харуул E. Цэргийн харуул
24. XVII зууны сүүлчээс XIX зуун хүртэл Манжийн төрөөс Хятад худалдаачид иргэдийг Монголд бөөнөөр нь оруулахгүй, хязгаарласан бодлого явуулжээ. Үүний шалтгаан юу байв?
    1. Монголчуудыг холбоотон, түшиг болгох
    2. Цэрэг харуулын хэрэгт ашиглах
    3. Монголын эдийн засаг нь доройтохоос болгоомжлох
    4. Монголчуудаас эсэргүүцэл тэмцэл гарахаас болгоомжлох
    5. Монгол орныг улс төр, эдийн засгийн түшиц газар байлгах сонирхол
    A. 2, 4, 5 B. 1, 5 C. 1, 2, 5 D. 1, 3, 5 E. 1, 2, 3, 4, 5
25. Монголын түүхийн бидэнд мэдэгдэж байгаа анхны түүх бичлэгийн бүтээл юу вэ?
    A. Монголын нууц товчоо B. Алтан товч C. Судрын чуулган
    D. Чингисийн чулууны бичиг E. Их засаг хууль
26. Манжийн эрхшээлийн үед Хятадын худалдаачид эд бараа, мөнгийг Монголчуудад жилд …………%-ийн хүүтэйгээр зээлдүүлээд, …………… …….дотор өрийг төлж дуусгах шаардлага тавьдаг байв.
    A. 48%-ийн ........дөрвөн жилийн B. 18%-ийн ........ нэг жилийн
    C. 24%-ийн.........хоёр жилийн D. 30% -ийн……. гурван жилийн
    E. 36%-ийн ………гурван жилийн
27. Хэн, хэзээ шашны тэргүүн Анхдугаар богд Жавзандамба хутагтаар өргөмжлөгдсөн бэ?
    A. 1275 онд Төвдийн Пагва Лам B. 1639 онд Занабазар
    C. 1577 онд Төвдийн Содномжамц D. 1586 онд Автай сайн хаан
    E. 1418 онд Богд Зонхав
28. Халхын ноёд Манж Чин улсыг түшин дагах шийдвэрийг хэзээ, хаана гаргасан бэ?
    A. 1686 онд Заг Байдрагийн Хүрэн бэлчирийн чуулганаар
    B. 1640 онд Тарвагатайн Улаан бураагийн чуулганаар
    C. 1727 онд Буурын чуулганаар
    D. 1688 онд Ар элстэйн чуулганаар
    E. 1691 онд Долнуурын чуулганаар
29. Түүхийн сурвалжуудад улс төрийн бутралын үеийн тухай өгүүлэхдээ хэрэглэдэг “дөчин, дөрвөн 2” хэмээх хэллэг ямар утгыг илэрхийлдэг вэ?
    A. Эзэн харъяатын ёс B. Цэргийн зохион байгуулалт
    C. Мал сүргийн харьцаа D. Ар, Өвөр монгол
    E. Зүүн, баруун монгол
30. Манжаас тогтоосон хуулиар Монголын малчин ардуудыг суман ард, хамжлага ард, шавь ард хэмээн гурав хуваан хамжлагчлахаар тогтоожээ. Суман ард нь хэний хамжлага вэ?
    A. Монголын ноёд язгууртнуудын B. Тайж нарын
    C. Хутагт хувилгаадын D. Ван, гүнгийн
    E. Манжийн хааны ( төрийн)
31. 1911 оны үндэсний хувьсгалын дараа дөрвөдийн баруун, зүүн гарыг хоёр аймаг болгон зохион байгуулж, нэгийг нь Далай хан аймаг хэмээн нэрлэжээ. Нөгөө нь ямар нэртэй аймаг болсон бэ?
    A. Түшээт хан B. Сэцэн хан C. Сайн ноён хан
    D. Засагт хан E. Үнэн зоригт хан
32. Чингис хааны чулууны бичгийн жинхэнэ эх нь хаана хадгалагдаж байгаа вэ?
    A. Хархорумын ойролцоо B. Цэргийн музейд
    C. Санктпетербургын эрмитажад D. Францын Луврт
    E. Үндэсний түүхийн музейд
33. Монголын түүхэн сурвалж бичигүүдэд “Ухаант хаан” хэмээн алдаршсан хаан аль нь вэ?
    A. Мөнхтөмөр хаан B. Тогоонтөмөр хаан C. Доголон Төмөр хаан
    D. Гүнтөмөр хаан E. Өлзийттөмөр хаан

34. Монголчуудаас Манж нарт залгуулж байсан “Есөн цагааны алба”-нд аль нь багтах вэ?
    A. Дөрвөн цагаан морь, Таван цагаан тэмээ B. Таван цагаан морь, Дөрвөн цагаан тэмээ
    C. Зургаан цагаан морь, Гурван цагаан тэмээ D. Долоон цагаан морь, Хоёр цагаан тэмээ
    E. Найман цагаан морь, Нэг цагаан тэмээ
35. 1911 оны зун Халхын дөрвөн аймаг, Их шавийн эрх мэдэл бүхий ноёд, лам нар Жавзандамба хутагтад “бат оршил” өргөх үеэр Их хүрээний Эрдэнэ Шанзудбын яаманд хийсэн нууц зөвлөгөөнөөр ямар асуудал хэлэлцсэн бэ?
    A. Хувьсгал хийх тухай B. Манж, хятадуудыг хөөн гаргах тухай
    C. Шинэ засгийг бодлогыг хэрхэх тухай D. Орос улсаас тусламж авах тухай
    E. Зэр зэвсэг цуглуулах тухай
36. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө ерөнхий сайдын дараагийн үүргийг ямар яамны сайд гүйцэтгэж байсан бэ?
    A. Дотоод B. Гадаад C. Сангийн
    D. Шүүх E. Цэргийн
37. 1911 оны зун тусламж эрж очсон Монголын төлөөлөгчдөд Орос улсын эрх баригчид ямар хариу өгсөн бэ?
    A. Орос улс Монголын Чин улсаас тусгаарлах тэмцлийг бүрэн дэмжинэ
    B. Монгол улс Чин улсаас тусгаарлах цаг хэдийн болсон
    C. Монгол одоо Чин улсаас бүрэн тусгаарлах бололцоогүй
    D. Монгол одоо Чин улсаас бүрэн тусгаарлах бололцоотой
    E. Орос улс Монголын Чин улсаас тусгаарлах тэмцлийг дэмжих боломжгүй
38. 1911 оны Үндэсний хувьсгалын оюун санааны удирддагч хэн бэ?
    A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. VIII Богд Жавзандамба
    D. Түшээ гүн Чагдаржав E. Шанзудба Бадамдорж
39. Богд хаант Монгол улсын засгийн газрын Сангийн яамны тэргүүн сайдад хэнийг тохоон томилсон бэ?
    A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. Түшээ гүн Чагдаржав
    D. Далай ван Гомбосүрэн E. Эрдэнэ ван Намсрай
40. XIX зууны эцэс үед гэр харуулын нэг жилийн зардал тэр үеийн ханшаар …………………………… лан мөнгөтэй дүйж байжээ.
    A. 100 000 B. 150 000 C. 200 000
    D. 250 000 E. 300 000
41. Монголчууд манжийн эсрэг дангаар тэмцэхэд эдийн засгийн болон зэр зэвсгийн хүрэлцээгүй зэрэг бэрхшээл их тул Орос улсаас тусламж гуйн элч явуулах шийдвэрийг хэзээ хаанаас гаргасан бэ?
    A. 1911 оны зун Эрдэнэ Шанзудбын яаманд болсон нууц зөвлөгөөнөөс
    B. 1911 оны зун Богд уулын арын ой дотор болсон нууц зөвлөгөөнөөс
    C. 1911 оны зун Эрдэнэ Шанзудбын яамнаас
    D. 1911 оны зун VIII богд Жавзандамба хутагтаас
    E. 1911 оны зун Түшээт хан аймгийн хаад, ноёдоос
42. Бүгд ерөнхийлөн захирах яам байгуулагдахаас өмнө дэд сайдын үүргийг хэн гүйцэтгэж байсан бэ?
    A. Далай ван Гомбосүрэн B. Эрдэнэ ван Намсрай C. Чин ван Ханддорж
    D. Да лам Цэрэнчимэд E. Түшээ гүн Чагдаржав
43. Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газрын тэргүүн нь хэн байсан бэ?
    A. VIII богд Жавзандамба хутагт B. Чин ван Ханддорж
    C. Да Лам Цэрэнчиэд D. Түшээ гүн Чагдаржав
    E. Түшмэл Хайсан
44. 1911 онд Монголчууд ямар улсын ноёрхлыг түлхэн унагааж, төрийн тусгаар тогтнолоо сэргээсэн бэ?
    A. Хятад B. Манж Чин улс C. Орос
    D. Дундад иргэн улс E. Дундад улс
45. Шинэ засгийн бодлогыг монголд хэрэгжүүлэхээр 1910 онд Их хүрээнд томилогдон ирсэн манж сайд хэн бэ?
    A. Сү Чен Ван B. Чен И C. Саньдо
    D. Да Шэн Куй E. Тянь Идэ
46. 1913 онд Монгол улсын анхны сэтгүүлийг Ж.Цэвээн тэргүүтэй дэвшилтэт үзэл бүхий сэхээтнүүд үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь ямар нэртэйгээр гарсан бэ?
    A. Нийслэл хүрээний сонин бичиг B. Шинэ толь
    C. Оюунтүлхүүр D. Орчлонгийн сав шим
    E. Алтан дэвтэр
47. Дараах хүмүүсээс хэн нь Консулын бүлгэмийн гишүүн бэ?
    A. С.Данзан B. Ө.Дэндэв C. Д.Догсом
    D. С.Жамъян E. М.Дугаржав

48. Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн 1920 оны 06-р сарын 25-нд С.Данзангийн гэрт хамтран хуралдаж гаргасан түүхэн шийдвэр аль нь вэ?
    A. ЗОУ-аас тусламж хүсэх төлөөлөгчдийг томилсон
    B. Ноёдын бүлгэмтэй холбоо тогтоохоор тохирсон
    C. Ардын журамт цэрэг байгуулахаар шийдсэн
    D. Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлэхээр шийдсэн
    E. Гадаад Монголын автономит эрхийг сэргээсэн
49. ЗОУ-аас тусламж хүсэхээр Эрхүүд очсон Ардын намын анхны долоо тэнд ажил үүргээ хуваарилж нэг хэсэг нь нутаг орондоо нам, хувьсгалын үйл хэргийг явуулах үүрэг хүлээж Монгол руу буцсан билээ. Хэн хэнд энэ үүрэг оногдсон бэ?
    A. С.Данзан, Д.Бодоо
    B. Д.Сүхбаатар, Д.Чагдаржав
    C. Х.Чойбалсан, Д.Бодоо
    D. Д.Бодоо, Д.Догсом
    E. Д.Догсом, Х.Чойбалсан
50. 1921 оны хувьсгалын үр дүнд Монгол оронд ямар засаг тогтсон бэ?
    A. Ардын засаг
    B. Бүгд найрамдах засаг
    C. Хэмжээт эрхт хаант засаг
    D. Хэмжээгүй эрхт хаант засаг
    E. Ардын эрхт хэмжээт цаазат засаг
51. Түүхэн зүтгэлтнүүдийн харгалзах улсыг харгалзуулна уу.

| | |
|---|---|
| A. Модун | 1. Уйгур |
| B. Шелүнь | 2. Сяньби |
| C. Амбагян | 3. Нирун |
| D. Таньшихуай | 4. Хүннү |
| E. Моюнчур | 5. Хидан |

    A. A3, B4, C5, D2, E1
    B. A3, B4, C2, D5, E1
    C. A1, B4, C5, D2, E3
    D. A3, B2, C5, D4, E1
    E. A4, B3, C5, D2, E1
52. Хубилай хааны зарлигаар ...................... үсгийг ........... онд...................................... зохиожээ. (Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу)
    A. Али гали – 1587 – Аюуш гүүш
    B. Дөрвөлжин – 1269 - Чойжи-Одсэр
    C. Тод – 1648 – Зая бандид Намхайжамц
    D. Соёмбо – 1686 – Өндөр гэгээн Занабазар
    E. Дөрвөлжин – 1269 – Пагва лам
53. 1130 онд Хамаг Монголыг Хабул хан нэгтгэн захирчээ. Хабул ханы Хамаг Монголыг нэгтгэн захирсан оныг зууны тоололд шилжүүлнэ үү.
    A. XI зуун
    B. XII зуун
    C. XI зууны I хагас
    D. XII зууны I хагас
    E. XIII зууны I хагас
54. Эцэг, хүү, ач, гучийн холбоотон аль нь вэ? Зөв хариуг сонгоно уу.
    A. Хабул, Охинбархаг, Есүхэй, Хасар
    B. Хабул, Бартанбаатар, Есүхэй, Хасар
    C. Хабул, Хадаан, Есүхэй, Хасар
    D. Хабул, Бартанбаатар, Хадаан, Есүхэй
    E. Хабул, Охинбархаг, Бартанбаатар, Есүхэй

## 2011 оны Монгол улсын түүхийн хичээлийн даалгаврын түлхүүр

| № | Хувилбарууд | | | |
|---|---|---|---|---|
| | A | B | C | D |
| 1 | B | D | A | A |
| 2 | E | D | A | B |
| 3 | B | B | A | B |
| 4 | D | C | C | D |
| 5 | D | E | D | E |
| 6 | C | B | D | D |
| 7 | D | D | C | C |
| 8 | A | E | A | A |
| 9 | E | A | A | D |
| 10 | A | A | D | E |
| 11 | A | D | C | A |
| 12 | B | B | B | B |
| 13 | A | C | E | E |
| 14 | A | A | A | C |
| 15 | B | C | C | A |
| 16 | D | C | C | B |
| 17 | B | E | B | B |
| 18 | C | B | C | B |
| 19 | B | D | D | C |
| 20 | D | D | D | B |
| 21 | B | B | B | C |
| 22 | B | E | D | A |
| 23 | E | C | C | A |
| 24 | B | C | C | E |
| 25 | E | A | C | A |
| 26 | B | C | B | E |
| 27 | A | D | C | B |
| 28 | D | D | D | D |
| 29 | E | D | D | E |
| 30 | D | B | A | E |
| 31 | D | E | A | E |
| 32 | E | B | C | C |
| 33 | A | C | D | B |
| 34 | D | C | B | E |
| 35 | D | D | B | C |
| 36 | E | B | D | B |
| 37 | A | D | D | C |
| 38 | A | A | A | C |
| 39 | D | D | D | C |
| 40 | D | D | C | B |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **41** | C | D | E | B |
| **42** | D | E | D | C |
| **43** | D | D | E | D |
| **44** | D | C | D | B |
| **45** | D | D | C | C |
| **46** | D | E | C | B |
| **47** | D | A | C | D |
| **48** | A | D | D | A |
| **49** | E | E | D | D |
| **50** | D | C | D | E |
| **51** | C | D | E | E |
| **52** | E | B | D | E |
| **53** | B | D | A | D |
| **54** | D | C | B | B |